

БИДНИЙ ЭРХЭМ ЗОРИЛГО

Даяаршлын эринд ажиллаж, амьдрах чадвартай, өндөр мэдлэгтэй мэргэжилтэн бэлтгэж, Монгол орныхоо одоо, ирээдүйн хөгжилд хувь нэмэр оруулна.

ЗОХИОМЖ ХЭВЛЭЛИЙН ЗОРИЛГО

Зохиомж дээд сургуулийн эрдэмтэн багш, эрдэм шинжилгээний ажилтанууд болон бакалавр, магистрын зэргээр өдөр болон оройн ангид сурч буй нийт оюутануудыг шаардлагатай мэдээ мэдээллээр хангах орчныг бүрдүүлэхэд оршино.

ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм оюутнууд аа, Олон Улсын Бизнес Технологийн Зохиомж Дээд сургууль нь Монгол Улсын дээд боловсролын хурдацтай хөгжин дэвшиж дүй тэргүүний байгууллага юм.

Тус сургуульд элсэн орсон эх орны чадварлаг ирээдүй оюутан залуус та бүхний нэгэн цөийн түүхийг амжилт бүтээл, амьдралаараа дичилцэж гэгээн цүйлэт хөтлөж замыг бид халтгаа дүй болгохоор эрдмийн их өргөөндөө журан цугларлаа. Эх орон, хүн төрөлхтний хүмүүнлэг цүйлэт хувь нэмрээ оруулах, Зохиомж их сургуулийг цогцлоож зорилт бидэнд бий.

Хүн бүгдэд адил эхлэл, ижил заяа, боломж байдаг чамьдралд олон өнгө зэрэгцэн байдаг. Хичээж, өөрийгөө дайчлан суралцаж чадаан нь эрдэм ухааныг олж авч насан туршидаа ухаанарт амьдралаа зориулах мэргэжлээ чадварлаг эзэмшдэг.

Амжилтын шигдэт түлхүүр-хичээл зүтгэл билээ. Эрхэм оюутнууд та нартаа амжилт хүсье.

Б.ЦОГТМБАЯР

БИЗНЕСИЙН УХААНЫ ТЭНХИМИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО

Чанартай сургалт, судалгаа, үйлчилгээ бүхий хөтөлбөрөөр иргэдийн оюуны чадварыг сайжруулж нийгмийн хөгжлийг урагшлуулна.



Валютын ханш

	АНУ доллар	1,888.44
	Евро	2,295.40
	Японы иен	15.78
	Швейцар франк	1,908.67
	Шведийн крон	244.19
	Английн фунт	2,938.98
	ОХУ-ын рубль	33.97
	БНХАУ-н юань	304.59
	БНСУ-ын вон	1.73
	Канадын доллар	1,627.54
	Малайзын ринггит	540.33
	Туркийн лира	811.95

Зээлжих зэрэглэлийг тогтоодог болно



оруулагчдад хамгийн бодитойгоор өгч чаддаг.

Тиймээс Санхүүгийн зохицуулах хорооноос зээлжих зэрэглэл тогтоох үйлчилгээг санхүүгийн зах зээлд нэвтрүүлэхэд анхаарч эхэлжээ. Тус хороо маргааш “Зээлжих болон санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох тогтолцоог Монгол Улсад хөгжүүлэх, түүний ач холбогдол” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах юм байна. Хэлэлцүүлэгт Монголбанк, Сангийн яам зэрэг төрийн байгууллагууд, МҮХАҮТ, Монголын Хөрөнгийн бирж, арилжааны банкууд, үнэт цаас, даатгалын компаниуд, банк бус санхүүгийн байгууллагууд, аудит, санхүүгийн зах зээл дэх мэргэжлийн холбоод, групп компаниудын удирдлагууд оролцоно. Тэдгээр хүмүүс зээлжих зэрэглэл тогтоох үйлчилгээний ач холбогдол, олон улсын туршлага, Монгол Улсын санхүүгийн зах зээлд хэрхэн нэвтрүүлж, хөгжүүлэх, цаашдын үр бүтээлтэй хамтын ажиллагааны талаар санал солилцох юм.

Монгол Улсын зээлжих зэрэглэлийг өсгөлөө, бууруулаа, Монголын томоохон банкуудын зээлжих зэрэглэл өөрчлөгдлөө гэсэн мэдээллүүд ойр ойрхон цацагддаг. Харин дотооддоо компани, аж ахуйн нэгжийн хувьд зээлжих зэрэглэл тогтоодог байгууллага манай улсын хувьд одоогоор огт байхгүй юм. Зээлжих зэрэглэлийн байгууллага тухайн зээлдэгч нь санхүүгийн үүргээ хугацаандаа барагдуулж чадах эсэх төсөөллийг хөрөнгө

Банкны холбооныхон удирдлагуудаа солив

Монголын банкны холбооныхон удирдлагуудаа сольсон байна. Тус холбоог Худалдаа хөгжлийн банк"-ны гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч О.Орхон удирдахаар болжээ. Тэгвэл холбооны дэд ерөнхийлөгчөөр “Ариг” банкны гүйцэтгэх захирал Д.Төмөрхүү, холбооны дэмжих гишүүн болох Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирал Б.Лхагвасүрэн нар томилогджээ.

Энэ холбооны ерөнхийлөгчөөр өнгөрсөн хоёр жил “Хас” банкны гүйцэтгэх захирал М.Болд ажилласан бол дэд ерөнхийлөгчөөр нь “Худалдаа хөгжлийн банк”-ны гүйцэтгэх захирал Б.Мэдрээ, ХААН банкны гүйцэтгэх захирал Норихико Като, “Голомт” банкны Эрсдэлийн удирдлагын газрын захирал М.Чингүн нар ажиллаж байсан юм.





Төсөв тэлж, мөнгөний бодлого хатуурах уу?

Монгол банкны Мөнгөний бодлогын зөвлөл өчигдрөөс хуралдаж эхэлжээ. Ингээд эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, улсын төсөв, төв банкнаас ирэх онд хэрэгжүүлэх мөнгөний бодлогын уялдааг харгалзан үзэж бодлогын хүүгээ нэмэх, эсвэл хэвээр хадгалж үлдэх эсэхийг шийдэх юм. Уг зөвлөл 2-3 удаа хуралдаж байж, бодлогын

шийдвэрээ гаргадаг аж. Тэгэхээр ирэх долоо хоногийн эхээр ямар шийдвэр гаргах нь тодорхой болох нь. Хамгийн гол нь улсын төсвийн сахилга бат, бодлогоос ямар шийд гарах нь ихээхэн хамаарна. Учир нь төсвийн бодлогоор мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлж байвал төв банк бодлогын хүүгээ өсгөнө. Төсвийн тэлэх бодлого нь татвар бууруулж, эдийн засаг дахь худалдан авалтыг дэмждэг. Мөн Засгийн газрын татаас өснө. Энэ бүгд нь эдийн засагт бараа бүтээгдэхүүний эрэлт өсгөж инфляц хөөрөгддөг. Тэгвэл төсвийн хумих бодлого эдийн засагт үүний эсрэг үйлчлэл үзүүлдэг билээ. Гэтэл манай улсын төсөв жил бүр тэлж орлого, зарлагаа өндрөөр төсөөлсөөр ирсэн. Тухайлбал, энэ оны төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 7.2 их наяд төгрөг буюу ДНБ-ий 35 хувьтай тэнцэнэ хэмээн төсөөлөв. Зарлага нь 7.6 их наяд төгрөг буюу ДНБ-ий 37 хувьтай тэнцэх тооцоо хийсэн. Өнөөдөр төсвийн орлого тасарч буй тул тодотгол хийж, нийт зарлага нь 5.3 их наяд төгрөгөөр хэмжигдэнэ хэмээн тооцсон. Ингээд алдагдал нь 416 тэрбум төгрөг байхаар төлөвлөж байлаа.



Гэтэл төсвийн орлого энэ оны эцэст нэг их наяд төгрөгөөр тасарч магадгүй бололтой. Ирэх онд төсвийн орлогыг 1.3 тэрбум төгрөг нэмж тооцсон. Өөрөөр хэлбэл, төсвийн орлого 7.1 их наяд, зарлага нь 7.6 их наяд төгрөг байна гэж үзлээ. Ингээд төсвийн алдагдал 478 тэрбум төгрөг гарах тооцоо хийв. Эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлаас үзвэл төсвийн орлого ингэж нэмэгдэх боломжгүй гэдгийг эдийн засагчид судлаач нар хэлж буй юм. Ирэх жилийн төсвийг танасан гэдэг. Жишээ нь аймаг орон нутгийн төсвийн цалингаас бусад бүх зардлыг 30 хувиар танаж буурууллаа гэсэн. Мөн төрийн албаны илүү орон тоог цомхотгох, гадаад томилолтын зардлыг 50 хувиар бууруулах арга хэмжээ авсан гэж тайлбарлаж буй. Гэвч эдийн засагчдын үзэж буйгаар төсвийн зардлыг 1.2 их наяд төгрөгөөр бууруулж байж хямралыг сөрсөн эерэг үр дүн гарна хэмээж байгаа юм. Тэгэхээр төсвийг энэ хэмжээнд танаж чадаагүй тул Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл бодлогын хүүгээ нэмэх шийдвэр гаргах магадлал тун өндөр байна.


Учир нь, ирэх онд улсын төсөв мөн л тэлэлттэй байхаар батлагдсан, төлбөрийн тэнцэл алдагдалтай хэвээр байгаа.

Мөн гадаадын шууд хөрөнгө оруулалт сэргээгүй юм. Хэрэв Монголбанк бодлогын хүүгээ өсгөвөл арилжааны банкуудын зээл олгох үйл ажиллагаа хумигдана. Иймд бизнес, хөрөнгө оруулалтын идэвхжил буурч, царцанги байдалд ордог. Өөрөөр хэлбэл, бид бүсээ бүр чангалж эдийн засаг сайжраасай хэмээн залбирах гарц л үлдэх юм. Товчхондоо

арилжааны банкууд зээлд гаргах мөнгөнийхөө дийлэнхийг төв банкинд өндөр хүүтэй хадгалуулна. Эдийн засгийн цусны эргэлт болсон мөнгө төв банкинд очиж царцана гэсэн үг. Төв банк бодлогын хүүгээ өнгөрсөн оны зургадугаар сар хүртэл 10.5 хувьд хэвээр хадгалж байв. Харин долдугаар сарын 31-ний өдөр төлбөрийн тэнцлийн хүндрэлийг зөөлрүүлэх, инфляцийг хазаарлах, дунд болон урт хугацаанд санхүүгийн тогтвортой байдлыг хангах, макро эдийн засгийн тогтвортой байдалд учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор мөнгөний бодлогын хүүг 1.5 нэгж хувиар нэмэгдүүлсэн билээ. Ингээд мөнгөний бодлогын хүү 12 хувь болсон. Үүний дүнд инфляцын түвшин тогтворжиж байна гэж эдийн засагчид хэлдэг. Энэ бүгдээс үзэхэд инфляцыг бууруулах улмаар дунд хугацааны зорилтот түвшин долоон хувьд байлгахын тулд нэг талаас улсын төсвийг тодотгож, төсвийн зардлыг бууруулж зохистой болгох учиртай. Үүнээс гадна эдийн засагт орж ирэх гадаад валютын урсгалыг нэмэгдүүлж төлбөрийн тэнцлийг ашигтай болгох шаардлага Засгийн газарт тулгараад буй юм.



Хөгжлийн банк 300 сая доллар зээллээ



Дэд бүтэц, барилга, үйлдвэржилт, эрчим хүч зэрэг томоохон төслийн санхүүжилтийг Хөгжлийн банкнаас гаргаж байгаа. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын хөгжлийг түлхүүрдэх үүрэгтэйгээр байгуулагдсан Хөгжлийн банк Швейцарийн Кредит Свисс, Японы Сумитомо Мицуи зэрэг олон улсын арилжааны таван банкнаас хөрөнгө босгох үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан байна. Тус банк өчигдөр Швейцарийн Кредит Свисс, Японы Сумитомо Мицуи зэрэг банкны удирдлагуудтай хамтран зээлийн гэрээнд гарын үсэг зуржээ. УИХ болон Засгийн газрын тогтоолын дагуу тээвэр, барилга хот байгуулалт, эрчим хүч, уул уурхай зэрэг эдийн засгийн голлох салбарт Хөгжлийн банк тодорхой хэмжээний санхүүжилтийг гаргах үүрэгтэй. Гэхдээ эдгээр төслүүдэд үлдэгдэл санхүүжилтийг олгох мөнгө байхгүй болсон талаар эх сурвалж мэдээлсэн. Тухайлбал, Чингис бондоор хэрэгжүүлж байсан дэд бүтэц, барилга, эрчим хүчний томоохон төслүүдийг санхүүжүүлэх нэмэлт санхүүгийн эх үүсвэрийг татан төвлөрүүлэх шаардлагатай болсон учраас дээрх 300 сая

долларыг зээлээр авч байгаа юм байна. Энэ зээлийн батлан даалтыг Засгийн газар гаргаж байгаа ажээ.

Швейцарийн Кредит Свисс, Японы Сумитомо Мицуи зэрэг банкнаас зээлсэн 300 сая долларын зээлийн хугацаа нь долоон жил гэнэ. Энэ мөнгийг зөвхөн стратегийн ач холбогдол бүхий эрчим хүчний салбар, үйлдвэрлэл /экспортыг дэмжих импортыг орлох үйлдвэрлэл/, дэд бүтэц /зам, төмөр зам, байгууламжууд/, уул уурхай салбаруудад нэмэлт санхүүжилт хэлбэрээр олгох юм байна. Ялангуяа уул уурхайн гол төслүүдийг санхүүжүүлэхээр төлөвлөж байгаа аж. Энэ зээл нь Хөгжлийн банкны авч байгаа анхны сендикат зээл гэдгийг тус банкны удирдлагууд онцолсон юм.

Хөгжлийн банк өмнө нь Сү.Батболдын Засгийн газрын үед олон улсын хөрөнгийн зах зээлээс босгосон 580 сая долларын зээлийг ирэх 2017 оноос буцаан төлөх юм. Таван жилийн хугацаатай энэ бондыг жилийн 5.75 хувийн хүүтэйгээр олон улсын нэр хүнд бүхий хөрөнгө оруулалтын ING, Deutsche Bank, HSBC банкуудтай хамтран арилжаалсан билээ. Мөн 2017 онд олон улсын хөрөнгийн зах зээлээс босгосон Чингис бондын 500 сая долларын зээлийн буцаан төлнө. Тиймээс энэ өрийг төлөх хөрөнгийг ирэх оны улсын төсөвт нөөцлөх ёстой хэмээн эдийн засагчид зөвлөж байгаа юм. Хэдийгээр эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан манай улсын зээлжих зэрэглэл буурч байгаа хэдий ч олон улсад Монголыг гэх сонирхол, ялангуяа уул уурхайд хөрөнгө оруулалт хийх хүсэл гадныханд байгаа талаар ч Швейцарийн Кредит Свисс банкны төлөөлөгч хэлсэн. Энэ мөнгөний эхний ээлж нь өнгөрсөн есдүгээр сард Хөгжлийн банкны дансанд орсон билээ.

Гадаад валютын нөөц: 1.3 тэрбум ам.доллар



Монголбанкны албан сайтад Монгол Улсын гадаад валютын нөөц өнгөрсөн аравдугаар сарын байдлаар 1398.1 сая ам.доллар байна гэж мэдээлжээ.

Гадаад валютын нөөцийн талаарх мэдээллийг Монголбанк урьд нь улирлын хоцрогдолтойгоор гаргадаг байсан бол энэ оны долдугаар сараас эхлэн өмнөх сарын мэдээллийг гаргаж, өөрийн вэб хуудсаараа олон таниулах болсон байна. Төв банкнаас “Улсын гадаад валютын нөөц багасч байгаа нь үнэн ч барагдаж үгүй болоогүй” гэдгийг онцлон тодотгосон юм.

Төв банк гадаад валютын нөөцөөсөө дуудлага явуулдаг ажээ. Хамгийн сүүлд буюу оноодор болсон дуудлага худалдаагаар гадаад валютын своп, форвард хэлцлүүд хийжээ. Банкууд 120.0 сая ам.доллар худалдах ам.долларын своп хэлцэл, 20.0 сая юань худалдан авах юанийн своп хэлцэл байгуулах санал ирүүлж, Монголбанк саналуудыг 100 хувь биелүүлсэн байна.

Бизнесийн ухааны тэнхимийн спортлог оюутан



Гадаад худалдаа гаалийн удирдлагын 3-р курсын оюутан Ц.Отгон-Эрдэнэ нь нийгэм олон нийтийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцдог бөгөөд хөдөлмөрч, шаргуу, бусадтай эвссэг, нийтэч зантай, спортын онцгой амжилттай манай шилдэг оюутны нэг юм.

Түүний спортын амжилтуудаас:

2008, 2009, 2010 оны "Өсвөрийн" Боксын Улсын Аварга шалгаруулах тэмцээний Алтан медаль,

2010, 2011 оны "Залуучуудын" Боксын Улсын аварга шалгаруулах тэмцээний Алтан медаль,

2012, 2013, 2014 оны "Насанд хүрэгчдийн" Улсын аварга шалгаруулах тэмцээний Мөнгөн медаль,

2014 онд Дорнод аймагт зохиогдсон МУ-ын Гавъяат дасгалжуулагч Ё.Төмөрбатаа багшийн нэрэмжит Боксын Олон улсын тэмцээний Алтан медаль,

2014 онд ХБНГУ-д зохиогдсон Олон улсын тэмцээний Алтан медаль,

2014 онд Кипр улсад зохиогдсон Олон улсын тэмцээний мөнгөн медаль тус тус хүртэн

2014 онд Оюутны Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцсон.

Хангайтан боксын клубээс гараагаа эхэлсэн тэрээр одоо МУ-ын Үндэсний шигшээ багийн тамирчин, Спортын мастер бөгөөд 2013 онд "Биеийн тамирын Тэргүүний ажилтан" цол тэмдэгээр шагнагдсан юм.

Дэлдэн чих булан



- Бизнесийн ухааны тэнхимийн Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй, татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч, Зохиомж дээд сургуулийн дэд профессор цолтой М.Уранчимэг багш маань Сангийн яамны жуух бичгээр, бизнесийн удирдлагын магистр, докторант П.Энхнасан багш маань Монголын Залуучуудын Холбооны Тэргүүний залуу алтан медалиар тус тус шинэ оны босгон дээр шагнагдлаа. Бизнесийн ухааны тэнхимийн өмнөөс ажлын өндөр амжилт болон аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.
- 2011 оны төгсөгч Н.Түвшинбаяр нь "Банкны дампуурлыг бууруулах арга зам" сэдвээр БНСУ-д Бизнесийн удирдлагын магистрын зэрэг амжилттай хамгааллаа.

